



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот


Нийслэлийн өмчид барилга байгууламж
эд хөрөнгө бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар Баянзүрх, Багахангай, Налайх, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт тус тус баригдаж ашиглалтад орсон, нийт 4,188,626,156 (дөрвөн тэрбум нэг зуун наян найман сая зургаан зуун хорин зургаан мянга нэг зуун тавин зургаа) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад дурдсан 7 барилга байгууламж, дугуйн зам бүхий нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Б.Батбямба)-д даалгасугай.


ДАРГА



Ж.БАТБЯЭСГАЛАН

1110103146

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
 44 дугаар тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ (төгрөгөөр)	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Бүртгэх байгууллага
1.	Ус түгээх байр	Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороо	2021	39,775,397	Улсын төсөв	"Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ
2.	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилга байгууламж	Багахангай дүүргийн 2 дугаар хороо	2021	619,456,247	Улсын төсөв	Багахангай дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв
3.	Нийтийн бие засах газар	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Туул голын хойд эрэг дагуу Маршалын гүүрнээс Баянзүрхийн гүүр хүртэл	2021	70,000,000	Нийслэлийн төсөв	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар
4.	Кофе худалдаалах цэг		2021	8,883,792		
5.	Кофе худалдаалах цэг		2021	4,441,896		
6.	Кофе худалдаалах цэг		2021	4,441,896		
7.	Дугуйн зам бүхий нийтийн эзэмшлийн эд хөрөнгө		2021	3,097,934,943		
8.	Зуухны барилга, байгууламжийн өргөтгөл шинэчлэлт	Налайх дүүргийн 5 дугаар хороо	2021	343,691,985	Нөөц хөрөнгө	Налайх дүүргийн Чандмань налайх ОНӨААТҮГ
Нийт дүн				4,188,626,156		